# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2026/143/НА-СТА-ТШ3**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Даваанinfoям<br>Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn<br>Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br>Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 02. 25 № 01/150

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
С.АДЪЯА ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Биеийн тамир спортын газрын удирдлагын үйл ажиллагаа хангалтгүй, нягтлан бодох бүртгэл тайлагнал нь анхан шатны баримт материалаар дэмжигдээгүй, аудитаар илэрсэн зөрчлүүд нь үндсэн хөрөнгө, бараа материал, зардлын дансдад өргөн тархсан, өмнөх аудитаар өгсөн зөрчлүүдийг дахин давтан гаргасан зөрчлүүд түгээмэл байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох стандарт, хууль, журмын дагуу бэлтгэж ирүүлээгүй
2. Нягтлан бодох бүтгэл тайлагнал нь ойлгомжгүй, анхан шатны баримт материалаар бүрэн дэмжигдээгүй
3. Нягтлан бодогч солигдоход бараа материал, хөрөнгийн тооллого хийж баталгаажуулаагүйгээс бараа материалын дансанд биетээр байхгүй, тухайн цаг хугацаандаа зарлагадаагүй үлдэгдэлд бүртгэлтэй 42,224.2 мянган төгрөгийн эд зүйлсийг өмч хамгаалах комисс, удирдлагын тушаал шийдвэргүй дансаас хассан.
4. Тайланд онд албан хаагчдын цалинг зөрүүтэй тооцсон, бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд хавсран гүйцэтгэсний нэмэгдэл авсан, үндэслэлгүй урамшуулал авсан, шатахууны зардлыг хувийн хэрэгцээнд

зарцуулсан, байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн зэрэг нийт 7,230.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.1, 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан журмын 2.7 дах заалтыг тус тус зөрчсөн ба иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд бөхийн өргөөний барилгад 292,332.9 мянган төгрөгийн засварын ажил хийгдэж, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн IV/27 тоот тогтоолоор 474,188.9 мянган төгрөгийн ногоон заалны барилгыг шилжүүлэн авч бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, үндсэн хөрөнгө, бараа матеиралын бүртгэл тайлагнал, төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг зөрчсөнтэй холбоотой нийт 86,048.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, холбогдох шийдвэрийг гаргасан.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт, 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 94.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **33** | **АВЛАГА** | 103,289.41 | 1,500,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 0.00 | 1,500,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 103,289.41 | 0.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 103,289.41 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 161,642,413.00 | 104,795,584.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 61,888,313.00 | 41,424,034.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 61,888,313.00 | 41,424,034.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 99,754,100.00 | 63,371,550.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 981,500.00 | 881,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,951,000.00 | 8,706,650.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,318,500.00 | 2,653,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,500,000.00 | 0.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 27,652,900.00 | 23,804,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 51,350,200.00 | 27,326,000.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **161,745,702.41** | **106,295,584.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,764,570,582.82 | 4,356,888,831.08 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,783,866,832.82 | 3,300,694,297.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,658,715,441.19 | 3,425,237,332.99 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -438,566,819.04 | -573,953,875.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,600,000.00 | 33,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -22,866,666.83 | -28,466,666.87 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 126,108,075.82 | 158,993,498.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -67,721,799.64 | -100,145,960.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,640,000.00 | 79,369,005.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,522,473.72 | -27,861,657.45 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,176,772,812.00 | 1,177,009,232.09 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -725,291,736.96 | -843,086,612.54 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 980,703,750.00 | 1,056,194,533.99 |
| 39301 | Програм хангамж | 2,050,000.00 | 2,638,032.88 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,518,750.00 | -2,432,780.14 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 980,172,500.00 | 1,057,767,500.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -1,778,218.75 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,764,570,582.82** | **4,356,888,831.08** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,926,316,285.23** | **4,463,184,415.08** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,438,970.00 | 101,647,653.00 |
| **413** | **Өглөг** | 1,438,970.00 | 101,647,653.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,288,070.00 | 101,496,753.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 150,900.00 | 150,900.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 150,900.00 | 150,900.00 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,438,970.00** | **101,647,653.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,924,877,315.23 | 4,361,536,762.08 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,149,478,579.00 | 2,149,478,579.00 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан | 2,149,478,579.00 | 2,149,478,579.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 525,893,340.50 | 962,552,787.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 716,078,078.45 | 525,893,340.50 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -190,184,737.95 | 436,659,446.85 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,249,505,395.73 | 1,249,505,395.73 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,924,877,315.23** | **4,361,536,762.08** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,926,316,285.23** | **4,463,184,415.08** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,358,235,550.00** | **1,573,896,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 907,978,900.00 | 960,982,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 907,978,900.00 | 960,982,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 215,256,650.00 | 381,598,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 201,695,000.00 | 323,930,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,189,400.00 | 11,950,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,372,250.00 | 45,717,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 235,000,000.00 | 231,315,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 235,000,000.00 | 231,315,800.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **22,758,176.00** | **875,300,173.57** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,758,176.00 | 875,300,173.57 |
| 120009 | Бусад орлого | 278,176.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 18,480,000.00 | 875,300,173.57 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,000,000.00 | 0.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,380,993,726.00** | **2,449,196,773.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,571,178,463.95** | **2,012,537,326.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,554,209,032.07 | 1,887,153,950.21 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 700,583,551.69 | 787,452,139.97 |
| 210101 | Үндсэн цалин | 455,596,555.58 | 514,946,163.95 |
| 210102 | Нэмэгдэл | 116,510,196.11 | 148,662,391.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,792,500.00 | 79,471,470.59 |
| 210104 | Урамшуулал | 74,684,300.00 | 42,910,113.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 1,462,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,089,845.31 | 101,553,603.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,769,977.66 | 72,173,794.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,019,032.08 | 7,331,919.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,793,795.35 | 3,718,691.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,496,316.07 | 3,665,759.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,010,724.15 | 14,663,438.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 190,088,069.77 | 258,551,930.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,936,246.00 | 8,440,059.93 |
| 210302 | Түлш, халаалт | 171,999,999.77 | 245,263,245.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,151,824.00 | 4,848,626.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 62,788,718.94 | 80,299,887.87 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,002,850.00 | 1,762,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 53,184,500.00 | 56,288,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,177,918.94 | 3,006,742.87 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 550,000.00 | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,873,450.00 | 4,330,305.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 14,511,940.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,442,500.00 | 8,894,390.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 3,166,140.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,442,500.00 | 5,728,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,311,600.00 | 27,125,584.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,311,600.00 | 27,125,584.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,502,000.00 | 2,112,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,502,000.00 | 2,112,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,201,500.00 | 5,344,150.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 845,000.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 529,700.00 | 2,419,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 117,700.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 17,500.00 | 57,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 32,400.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 485,000.00 | 609,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,174,200.00 | 2,258,950.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 480,201,246.36 | 615,819,864.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 232,365,800.00 | 304,582,339.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 247,835,446.36 | 311,237,525.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,969,431.88 | 125,383,376.51 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,067,800.00 | 59,440,474.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 58,440,474.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,321,800.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,746,000.00 | 1,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,883,721.65 | 21,633,577.14 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,883,721.65 | 21,633,577.14 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,017,910.23 | 44,309,325.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 441,000.23 | 31,600,177.07 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 576,910.00 | 12,709,148.30 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,571,178,463.95** | **2,012,537,326.72** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-190,184,737.95** | **436,659,446.85** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-190,184,737.95** | **436,659,446.85** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,358,235,550.00** | **1,573,896,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 907,978,900.00 | 960,982,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 907,978,900.00 | 960,982,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 215,256,650.00 | 381,598,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 201,695,000.00 | 323,930,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,189,400.00 | 11,950,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,372,250.00 | 45,717,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 235,000,000.00 | 231,315,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 235,000,000.00 | 231,315,800.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **278,176.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 278,176.00 | 0.00 |
| 120009 | Бусад орлого | 278,176.00 | 0.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,358,513,726.00** | **1,573,896,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,326,773,426.00** | **1,564,656,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,309,803,994.12** | **1,439,273,223.49** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 700,686,841.10 | 787,452,139.97 |
| 210101 | Үндсэн цалин | 455,699,844.99 | 514,946,163.95 |
| 210102 | Нэмэгдэл | 116,510,196.11 | 148,662,391.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,792,500.00 | 79,471,470.59 |
| 210104 | Урамшуулал | 74,684,300.00 | 42,910,113.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 1,462,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,089,845.31 | 101,450,313.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,769,977.66 | 72,070,505.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,019,032.08 | 7,331,919.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,793,795.35 | 3,718,691.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,496,316.07 | 3,665,759.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,010,724.15 | 14,663,438.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 188,799,999.77 | 166,952,747.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,800,000.00 | 8,576,305.93 |
| 210302 | Түлш, халаалт | 171,999,999.77 | 152,617,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000,000.00 | 5,759,242.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,979,968.94 | 16,972,156.87 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,177,200.00 | 271,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,452,500.00 | 1,800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,177,918.94 | 3,006,742.87 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 550,000.00 | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,622,350.00 | 11,494,414.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,399,000.00 | 32,762,875.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,399,000.00 | 32,762,875.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,502,000.00 | 2,112,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,502,000.00 | 2,112,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,401,500.00 | 5,344,150.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,045,000.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 529,700.00 | 2,419,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 117,700.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 17,500.00 | 57,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 32,400.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 485,000.00 | 609,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,174,200.00 | 2,258,950.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 290,944,839.00 | 326,226,440.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 290,944,839.00 | 326,226,440.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,969,431.88** | **125,383,376.51** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,067,800.00 | 59,440,474.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 58,440,474.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,321,800.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,746,000.00 | 1,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,883,721.65 | 21,633,577.14 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,883,721.65 | 21,633,577.14 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,017,910.23 | 44,309,325.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 441,000.23 | 31,600,177.07 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 576,910.00 | 12,709,148.30 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)** | **1,326,773,426.00** | **1,564,656,600.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **31,740,300.00** | **9,240,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **31,740,300.00** | **9,240,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 31,740,300.00 | 9,240,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 31,740,300.00 | 9,240,000.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **31,740,300.00** | **9,240,000.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-31,740,300.00** | **-9,240,000.00** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,149,478,579.00 | 1,249,505,395.73 | 716,078,078.45 | 4,115,062,053.18 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **716,078,078.45** | 4,115,062,053.18 |
| C09 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -190,184,737.95 | -190,184,737.95 |
| C10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **525,893,340.50** | 3,924,877,315.23 |
| C11 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **525,893,340.50** | 3,924,877,315.23 |
| C12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **525,893,340.50** | 3,924,877,315.23 |
| C19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 436,659,446.85 | 436,659,446.85 |
| C20 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **962,552,787.35** | 4,361,536,762.08 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| **12200** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,283,583,100.00 | 972,502,300.00 | 311,080,800.00 | 75.76 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,052,488,300.00 | 972,502,300.00 | 79,986,000.00 | 92.40 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 1,283,583,100.00 | 972,502,300.00 | 311,080,800.00 | 75.76 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,319,353,977.07 | 1,160,476,822.93 | 158,877,154.14 | 87.96 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,115,590,600.00 | 1,079,402,771.79 | 36,187,828.21 | 96.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 715,537,400.00 | 700,156,195.99 | 15,381,204.01 | 97.85 |
| 210101 | Үндсэн цалин | 393,542,900.00 | 429,112,219.97 | -35,569,319.97 | 109.04 |
| 210102 | Нэмэгдэл | 199,688,600.00 | 148,662,391.47 | 51,026,208.53 | 74.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 71,708,600.00 | 79,471,470.59 | -7,762,870.59 | 110.83 |
| 210104 | Урамшуулал | 50,597,300.00 | 42,910,113.96 | 7,687,186.04 | 84.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,466,900.00 | 85,291,167.00 | 3,175,733.00 | 96.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,152,400.00 | 57,961,775.80 | 2,190,624.20 | 96.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,076,800.00 | 6,819,314.80 | 257,485.20 | 96.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,545,900.00 | 3,462,389.40 | 83,510.60 | 97.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,538,300.00 | 3,409,457.40 | 128,842.60 | 96.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,153,500.00 | 13,638,229.60 | 515,270.40 | 96.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 188,617,200.00 | 166,952,747.93 | 21,664,452.07 | 88.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,000,000.00 | 8,576,305.93 | 15,423,694.07 | 35.73 |
| 210302 | Түлш, халаалт | 152,617,200.00 | 152,617,200.00 | 0.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,000,000.00 | 5,759,242.00 | 6,240,758.00 | 47.99 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,908,400.00 | 4,296,983.87 | 5,611,416.13 | 43.37 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,434,000.00 | 271,000.00 | 1,163,000.00 | 18.90 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,992,800.00 | 2,242,483.87 | 750,316.13 | 74.93 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,196,300.00 | 400,000.00 | 796,300.00 | 33.44 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,485,300.00 | 583,500.00 | 2,901,800.00 | 16.74 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 42,477,600.00 | 32,541,875.00 | 9,935,725.00 | 76.61 |
| 210604 | Урсгал засвар | 42,477,600.00 | 32,541,875.00 | 9,935,725.00 | 76.61 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,112,400.00 | 2,112,400.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,112,400.00 | 2,112,400.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,368,400.00 | 1,336,762.00 | 4,031,638.00 | 24.90 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 537,500.00 | 0.00 | 537,500.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 447,900.00 | 0.00 | 447,900.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо | 99,800.00 | 57,000.00 | 42,800.00 | 57.11 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 49,800.00 | 0.00 | 49,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,495,900.00 | 609,000.00 | 886,900.00 | 40.71 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж | 2,737,500.00 | 670,762.00 | 2,066,738.00 | 24.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 63,102,300.00 | 86,714,640.00 | -23,612,340.00 | 137.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,102,300.00 | 86,714,640.00 | -23,612,340.00 | 137.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 203,763,377.07 | 81,074,051.14 | 122,689,325.93 | 39.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 172,163,200.00 | 59,440,474.00 | 112,722,726.00 | 34.53 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 59,344,600.00 | 58,440,474.00 | 904,126.00 | 98.48 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 111,818,600.00 | 0.00 | 111,818,600.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | 31,600,177.07 | 21,633,577.14 | 9,966,599.93 | 68.46 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | 1,319,353,977.07 | 1,160,476,822.93 | 158,877,154.14 | 87.96 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **368,889,451.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **368,889,451.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 368,889,451.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 87,295,943.98 |
| 210101 | Үндсэн цалин | 85,833,943.98 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,462,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,159,146.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,108,729.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 512,604.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 256,302.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 256,302.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,025,208.73 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,675,173.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 764,259.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,910,914.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,007,388.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,419,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,588,188.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 248,751,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 248,751,800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 381,598,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 381,598,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 323,930,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,950,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 45,717,800.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 135,502.4 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил илэрснээс 7,230.2 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт, 46,254.2 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 83,338.0 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

- Нягтлан бодогч Мягмар-Отгон нь тухайн тайлангийн хугацаанд санхүү бүртгэлийн ажил сайжирсан үзүүлэлтгүй, дотоод хяналт болон бусад хяналт шалгалтуудаар хангалтгүй ажилласан хөрөнгө шамшигдуулсан гэсэн үнэлэлт дүгнэлт авч байсан боловч ажлын үр дүн харгалзалгүй 1 473.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг бодож авсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, ЗГ-ын 2019 оны 5 тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.4. Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Сахилгын шийтгэлтэй 1 ажилтанд 381.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8.Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно. Засгийн газрын 2019 оны 5 -р тогтоолын "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 2.7. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Тайлангийн хугацаанд 1.246.5 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг худалдан авч удирдлагууд болон багш нарт өгсөн нь Хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Хэмнэлтийн тухай хуулийн15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: Үүнд 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

- Нягтлан бодогч Мягмар-Отгон 2025 оны бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд Байгууллагын даргын 2023 оны 6 сарын 30-ны Б/23 тоот тушаалаар Санхүү, аж ахуйн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэснээр өөрийн цалингийн 15%-иар тооцон 2.338.5 мянган төгрөгийн цалинг бодож авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.Төсвийн шууд захирагч нь 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, 14 дугаар зүйлийн 14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох" гэсэн заалт зөрчигдсөн байна.

- Шатахууны тооцооллыг шалган шатахуун түгээх станцтай тооцоо тулган баталгаажуулахад шатахууны хөнгөлөлтийн 470.0 мянган төгрөгийг бүртгэлд тусгалгүй анхан шатны баримтын бүрдэлгүй авч зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12 дугаар зүйлийн 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтууд зөрчигдөж байна.

- Албан хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 1.320.0 мянган төгрөг илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1.3, ЗГ-ын 2019 оны 06 тогтоолоор батлагдсан " Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох " журмын 2.2 Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал, 2.2.2. байрны зардал, 2.2.3. хоолны зардал".гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**5.2 Албан шаардлага**

- Спорт заалны түрээсийн гэрээ хийгдсэн байгууллагуудын 2.710.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”,14 дүгээр зүйлийн 14.4.5 “бүх орлого”, гэсэн заалтыг зөрчсөн.

- Тайлангийн хугацаанд бараа материалын дансанд биетээр байхгүй, тухайн цаг хугацаандаа зарлагадаагүй үлдэгдэлд бүртгэлтэй эд зүйлсийг өмч хамгаалах комиссоор шийдвэр гаргаагүй, удирдлагын тушаал шийдвэргүй бараа материал төрөл тус бүрийн зардалд тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2.санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; 5 дугаар зүйлийн 5.1.5.хэмжигдэхүйц байх, Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батлагдсан " Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бараа материалын бүртгэл хөтлөөгүй байна

- Шилэн дансанд 4 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого томиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", гэж заасныг хэрэгжүүлээгүй байна" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Цалингийн данстай холбоотой асуудал***

***<u>1.1 Илрүүлэлт</u>:***

Цалингийн тооцооллыг тушаал шийдвэр, цагийн бүртгэлтэй тулган шалгахад өвчтэй, чөлөөтэй ажилчдын өргөдөл гомдлыг шалгаж цалингийн тооцоололд оруулдаггүй өргөдөл гомдлыг дотоод журмын дагуу цохож бүртгэдэггүй цагийн бүртгэлийг үнэн зөв бодитой бүртгэдэггүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5.цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, 84 дугаар зүйлийн 84.5.Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Цалингийн бодолтыг хийхдээ анхан шатны баримтыг тулгуурлан хийх.

***2. Тайлагналын данстай холбоотой асуудал***

***1.2 Илрүүлэлт:***

Тайлангийн хугацаанд тус байгууллагын нягтлан бодогч солигдсон боловч ажил хүлээлцээгүй, тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй, ажил хүлээлцсэн акт байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна",12 дугаар зүйлийн 12.2.2 ".эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгө өр төлбөрийн тооллогыг заавал хийнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж:***

Эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгө өр төлбөрийн тооллогыг заавал хийнэ

***3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

***1.3 Илрүүлэлт:***

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 53.904.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй 65 нэр төрлийн 80 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн  20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчигдөж байна.

***Өгсөн зөвлөмж:***

Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох

***4. Зардлын данстай холбоотой асуудал***

***1.4 Илрүүлэлт:***

Цалингийн тооцооллыг шалгахад нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтийн цалинтай таарахгүй 4,953.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан  байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5.цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн  17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:***

Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж ажиллах

***5. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

***1.5  Илрүүлэлт:***

Ногоон заалны барилгыг бүртгэлд авах  шийдвэрийн дагуу бүртгэлд авсан боловч биетээр ирээгүй 200.0 төгрөгийн анхны өртөгтэй зөөврийн компьютер гэх хөрөнгө биетээр байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн  5.1.4.үнэн зөв байх; 5 дугаар зүйлийн 5.1.5.хэмжигдэхүйц байх,  Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

***Өгсөн зөвлөмж:***

Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах

***6. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

***<u>1.6 Илрүүлэлт:</u>***

Үндсэн хөрөнгийн дансанд сорил гүйцэтгэхэд хөрөнгийн бүртгэл хангалтгүй эд хариуцагчийн карт байхгүй, хөрөнгийг коджуулаагүй, биетээр байгаа хөрөнгө санхүүгийн тайлангийн хөрөнгийн бүртгэлтэй тохирохгүй, биетээр ашиглагдаж байгаа хөрөнгө бүртгэлд байхгүй, ашиглагдахгүй хөрөнгийг актлах шийдвэр гаргуулаагүй зэрэг зөрчилтэй байна. Энэ нь УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батлагдсан " Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" зөрчигдөж байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хариуцагчийн картыг шинэчлэн ажиллах

***7. Орлогын данстай холбоотой асуудал***

***<u>1.7 Илрүүлэлт:</u>***

Байгууллагын үйл ажиллагааны орлогыг бэлэн мөнгөөр авч зарцуулдаг, Бэлнээр авсан мөнгөний баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгдэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 13 дугаар зүйлийн13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд зөрчигдөж байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн тооцооллыг тушаал шийдвэр, цагийн бүртгэлтэй тулган шалгахад өвчтэй, чөлөөтэй ажилчдын өргөдөл гомдлыг шалгаж цалингийн тооцоололд оруулдаггүй өргөдөл гомдлыг дотоод журмын дагуу цохож бүртгэдэггүй цагийн бүртгэлийг үнэн зөв бодитой бүртгэдэггүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Тайлангийн хугацаанд тус байгууллагын нягтлан бодогч солигдсон боловч ажил хүлээлцээгүй, тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй, ажил хүлээлцсэн акт байхгүй байна | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Нягтлан бодогч Мягмар-Отгон нь тухайн тайлангийн хугацаанд санхүү бүртгэлийн ажил сайжирсан үзүүлэлтгүй, дотоод хяналт болон бусад хяналт шалгалтуудаар хангалтгүй ажилласан хөрөнгө шамшигдуулсан гэсэн үнэлэлт дүгнэлт авч байсан боловч ажлын үр дүн харгалзалгүй 1 473.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг бодож авсан байна. | 1 | 1,473.6 | 1 | 1,473.6 | | | | | | | | |
| Албан хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 1.320.0 мянган төгрөг илүү тооцож олгосон байна. | 1 | 1,320.0 | 1 | 1,320.0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сахилгын шийтгэлтэй 1 ажилтанд 381.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. | 1 | 381.6 | 1 | 381.6 | | | | | | | | |
| Спорт заалны түрээсийн гэрээ хийгдсэн байгууллагуудын 2.710.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг дутуу тайлагнасан байна. | 1 | 2,710.0 | | | 1 | 2,710.0 | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 53.904.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй 65 нэр төрлийн 80 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | 53,904.7 | | | | | 1 | 53,904.7 | | | | |
| Тайлангийн хугацаанд 1.246.5 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг худалдан авч удирдлагууд болон багш нарт өгсөн нь Хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна. | 1 | 1,246.5 | 1 | 1,246.5 | | | | | | | | |
| Цалингийн тооцооллыг шалгахад нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтийн цалинтай таарахгүй 4.953.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан байна. | 1 | 4,953.3 | | | | | 1 | 4,953.3 | | | | |
| Ногоон заалны барилгыг бүртгэлд авах шийдвэрийн дагуу бүртгэлд авсан боловч биетээр ирээгүй 200.0 төгрөгийн анхны өртөгтэй зөөврийн компьютер гэх хөрөнгө биетээр байхгүй байна. | 1 | 200.0 | | | | | 1 | 200.0 | | | | |
| Тайлангийн хугацаанд бараа материалын дансанд биетээр байхгүй, тухайн цаг хугацаандаа зарлагадаагүй үлдэгдэлд бүртгэлтэй эд зүйлсийг өмч хамгаалах комиссоор шийдвэр гаргаагүй, удирдлагын тушаал шийдвэргүй бараа материал төрөл тус бүрийн зардалд тайлагнасан байна. | 1 | 42,224.2 | | | 1 | 42,224.2 | | | | | | |
| Нягтлан бодогч Мягмар-отгон 2025 оны бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд Байгууллагын даргын 2023 оны 6 сарын 30-ны Б/23 тоот тушаалаар Санхүү, аж ахуйн албаны даргын ажлыг хавсран гүйцэтгэснээр өөрийн цалингийн 15%-иар тооцон 2.338.5 мянган төгрөгийн цалинг бодож авсан байна. | 1 | 2,338.5 | 1 | 2,338.5 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн дансанд сорил гүйцэтгэхэд хөрөнгийн бүртгэл хангалтгүй эд хариуцагчийн карт байхгүй, хөрөнгийг коджуулаагүй, биетээр байгаа хөрөнгө санхүүгийн тайлангийн хөрөнгийн бүртгэлтэй тохирохгүй, 24.280.0 мянган төгрөгийн ашиглагдахгүй хөрөнгийг актлах шийдвэр гаргуулаагүй зэрэг зөрчилтэй байна. | 1 | 24,280.0 | | | | | 1 | 24,280.0 | | | | |
| Байгууллагын үйл ажиллагааны орлогыг бэлэн мөнгөөр авч зарцуулдаг, Бэлнээр авсан мөнгөний баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгдэж байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Шатахууны тооцооллыг шалган шатахуун түгээх станцтай тооцоо тулган баталгаажуулахад шатахууны хөнгөлөлтийн 470.0 мянган төгрөгийг бүртгэлд тусгалгүй анхан шатны баримтын бүрдэлгүй авч зарцуулсан | 1 | 470.0 | 1 | 470.0 | | | | | | | | |
| **Дүн** | **15** | **135,502.4** | **6** | **7,230.2** | **2** | **44,934.2** | **7** | **83,338.0** | | | | |

**Нийцлийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансанд 4 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| **Дүн** | **1** | **-** | | | **1** | **-** | | | | | | |